

Нярай хүүхдийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр

Цагаач иргэд нярай хүүхдийн эмчилгээний төлбөрийг олгох энэхүү хөтөлбөрт хэрхэн хүсэлтээ ирүүлэх тухай?

Хүүхэд өөрийн арьс өнгө, шашин шүтлэг, төрсөн газар орон мөн хүйсний байдлаасаа үл хамааран эрүүл чийрэг өсөн торниж, өвсөн үедээ тохимжтой эмчилгээг цаг тухай үедээ авч байх заяамал эрхтэй төрсөн байдаг. Үзэсгэлэн гоо төрийн бус байгуулга болон Цагаач иргэдтэй хамдаа байгуулгын зүгээс эмнэлгийн үйлчилгээ авах боломжгүй орчин нөхцөлд амьдарч буй нярай хүүхдүүдийн эндэгдлийг багасгаж, цаашдын эрүүл бойжилтыг дэмжих зорилго дор эмчилгээний төлбөрийг олгон дэмжих энэхүү хөтөлбөрийг эхлүүлэхээр болсон ту та бүхэн сонирхсон зүйлээ лавлан асууж, өргөнөөр хамрагдахыг хүсэж байна.

■ Хүсэлт хүлээн авах хугацаа

2024 оны 3 сарын 14с 10 сарын 14 г хүртэл

(Хүсэлтийг байнга хүлээн авах бөгөөд, ирүүлсэн хүсэлтүүдээс сард 1 удаа сонгох болно.)

■ Хамрагдах иргэд

Солонгос улсад оршин суугч 7 -с доош насны хүүхэд ба тэр дундаа визний бүртгэлгүй, мөн оршин суух эрхэй ч эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй/ хамрагдсан ч дундаасаа тасалдсан хүүхдүүд.

(2024 оны байдлаар 2017 оны 1 сарын 1ний өдрөөс хойш төрсөн хүүхдүүд)

■ Хөтөлбөрийн хүрээ

- 1) Нэг хүүхдэд дээд тал нь 3 сая хүртлэх воны дэмжлэгийг үзүүлнэ.
- 2) Өвчний болон гэмтлийн улмаас эмнэлэгт хэвтэх юмуу мэс засал хийлгэх, мөн гэрээрээ эмчлүүлэх болон шаардлагатай шинжилгээнүүдийг хийлгэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх эмчилгээний төлбөрүүдийн тус тус дэмжин ажиллана.

■ Хүсэлтээ ирүүлэх арга

1. Хүсэлт ирүүлэх боломжит иргэд: Нярай хүүхдээ бойжуулж буй цагаач иргэд өөрсдийн биеэр бүртгүүлэх, мөн эсвэл цагаач иргэдтэй холбоотой байгуулгаар дамжуулан бүртгүүлэх.
※ Хүсэлт ирүүлж буй хүүхдийн асран хамгаалагчтай байнга холбоотой байж, цаашдаа хүүхдийн бойжилт, эмчилгээний тал дээр хяналт тавих боломж бүхий байгуулгаар дамжуулна.
2. Хүсэлт ирүүлэх арга: Цагаач иргэдтэй хамдаа ТББ-н вэбсайт (www.somi.or.kr)-с холбогдох анкетийг татан авч, бөглөснийхөө дараа шаардлагатай бусад бичиг баримтны хамтаар доорх мэйл хаягаар хүсэлтээ ирүүлнэ үү.

■ Хүсэлт ирүүлсний дараах үйл явц

- Хүсэлтийг хүлээн авах ► Хянах ► Хэрхэн сонгох тухай тайлбарлах
► Эмчилгээний төлбөрийг дансаар явуулах ► Үр дүнгийн тайлан хийх

■ Лавлах утас

Цагаач иргэдтэй хамтдаа Т. 051-818-4748 Е. somi3438@daum.net

몽골어